



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
АРВАЙХЭЭР СУМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 10 сарын 25 өдөр

Дугаар 37

Арвайхээр

Ээлжит хуралдаан товлон  
зарлах тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1 дэх заалтыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Арвайхээр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 07 дугаар Хуралдааныг 2018 оны 11 сарын 14-ний өдрийн Лхавга гарагт 10:00 цагт хуралдуулахаар товлон зарлаж, дараах асуудлыг хэлэлцсүгэй. Үүнд:

1.1. Хог хаягдлын хураамж шинэчлэн тогтоох тухай


1.2. Арвайхээр хотын ногоон байгууламжийг 2016-2026 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийн тухай

1.3. “Нэг өрх- Нэг ажлын байр” хөтөлбөрийн II дахь шатны хэрэгжилтийн явц, үр дүнгийн тухай

1.4. Газрын төлбөр, үнэлгээ тогтоох тухай

1.5. 2018 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, 2019 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө батлах тухай

2. Хурлаар хэлэлцүүлэх асуудлын бэлтгэлийг сайтар хангаж, холбогдох тооцоо, судалгааг гаргаж, төслийг 2018 оны 11 сарын 07-ны өдрийн дотор иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид болон Ажлын хороодод танилцуулахаар бэлтгэл хангахыг сумын Засаг дарга /О.Пүрэвдорж/, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /Ц.Тунгалаг/ нарт тус тус даалгасугай.

ДАРГА  Д.АМАРТҮВШИН